

## **ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

### **Нэг. Нутгийн удирдлага, зохион байгуулалтын талаар:**

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 3 удаа хуралдаж, 8 асуудал хэлэлцэж, 1 асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр, 2 асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжлахаар тус тус шийдвэрлэв.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг дарга 47 өргөдөл бичгээр хүлээн авч, 12 өргөдлийг шийдвэрлэж, 35 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 5, аймгийн Засаг даргын Тамгын газарт 23 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч, нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлт 87,5 хувьтай байна.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 19 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 15, биечлэн 4 иргэн санал, гомдол, шүүмжлэл ирүүлснээс санал хүсэлт 82, гомдол 11 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 14 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэн, 5 өргөдөл шийдвэрлэгдэхээр хүлээгдэж шийдвэрлэлт 73,7 хувьтай байна. Боловсролын салбарын чиглэлээр 1, эрүүл мэндийн чиглэлээр 1, орчны эрүүл ахуйн чиглэлээр 3, хууль эрх зүй 1, халаалт дулаан 2, цахилгаан эрчим хүч 1, бусад 10 санал хүсэлт хүлээн авсан байна.

Аймгийн Засаг дарга 1 удаагийн Пүрэв гарагийн иргэд хүлээн авч уулзах уулзалтаар 34 иргэний амаар биечлэн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч хариу өгч шийдвэрлэв. Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 5 санал хүсэлт, 2 гомдол хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж 4 санал хүсэлт, 2 гомдлыг шийдвэрлэн хариу өгч, 1 санал хүсэлт шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна.

Ардчилсан тогтолцоонд шилжиж, анхны ардчилсан Үндсэн хуулиа баталсны түүхт 25 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэв. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 113 дугаар тогтоолоор ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХ-ын ажлын албанаас УИХ-ын даргын нэрэмжит шатрын тэмцээнийг 17 суманд зохион байгуулж, шалгарсан 3 оролцогчийг Улаанбаатар хотод болох Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулж, Үндсэн хуулийн өдөрт зориулсан аймаг, сумын цолтой, залуу бөхчүүд оролцсон 64 бөхийн барилдаан, аймаг, сумын төвийн Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 ангийн сурагчдын дунд “Үндсэн хууль-миний амьдралд”, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд “Үндсэн хууль-миний эрх” зохион бичлэгийн уралдаан, 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Үндсэн хууль-миний амьдралд” АХА тэмцээн зохион байгуулж, орон нутгийн Ховдын мэдээ, Ховдын толь сонин, “ХоТВ”-ээр Үндсэн хуулийн үзэл баримтлал, ач холбогдолыг сурталчлав. Шинэ үндсэн хууль батлалцсан АИХ-ын депутат нарт хүндэтгэл үзүүлж, “Үндсэн хууль-25 жил” телевизийн ярилцлага хийж, аймгийн Музейд АИХ-ын депутатын булан нээж намтар эд зүйлсийг нь байршуулан алдрыг нь мөнхжүүлж, багш, эрдэмтэн судлаачид, иргэд, ахмад настнуудтай уулзалт хийх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулав.

Аймгийн Засаг дарга Д.Галсандондог сум, албан байгууллагуудын дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж, “2016 онд байгуулсан Үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, 2017 оны “Үр дүнгийн гэрээ байгуулав. Үр дүнгийн гэрээ байгуулах нь харилцан итгэлцэл, хамтын ажиллагаа, сахилга, хариуцлагыг дээшлүүлэн баталгаажуулж, ажил үйлсээ дүгнэн цэгнэх үндэс суурь болдог. Энэ онд аймаг, сум, хэлтэс, агентлагууд иргэдэд ямар ажил үйлчилгээ үзүүлж, ямар цаг хугацаанд хэрхэн бүтээн байгуулалт өрнүүлэх, хэдий хэрийн хөрөнгө шаардагдаж ажил үйлчилгээний алиныг нь улсын болон орон нутгаас санхүүжүүлэх зэрэг олон асуудалд харилцан үүрэг хүлээсэн гэрээ байгуулав.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:**

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 1 дүгээр сард улсын төсвөөс авах санхүүжилт бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгов. Төсвийн гүйцэтгэлийн 2016 оны 12 дугаар сарын мэдээгээр 2016 оны орлого урьдчилсан байдлаар Сангийн яамны орлогын хяналтын төлөвлөгөөгөөр 8,6 тэрбум төгрөг оруулахаас 8,6 тэрбум төгрөг төсөвт оруулж, төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөгөөр 9119,3 сая төгрөг оруулахаас 8647,0 сая төгрөг орж, төлөвлөгөө 472,2 сая төгрөгөөр буюу 6,2 хувиар, үүнээс татварын орлогоор 8272,7 сая төгрөг орохоос 7886,1 сая төгрөг орж, төлөвлөгөө 386,5 сая төгрөгөөр буюу 4,7 хувиар, татварын бус орлогоор 768,6 сая төгрөг орохоос 650,9 сая төгрөг оруулж, төлөвлөгөө 117,7 сая төгрөгөөр буюу 15,3 хувиар тус тус тасарсан байна. Орон нутгаас улсын төсвийн орлогод 2258,5 сая төгрөг оруулахаас 2371,4 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 5,0 хувиар давуулан биелүүлэв. Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 7959,3, ТЗШ-гээр 37711,8, ОНХС-ийн орлогын шилжүүлгээр 3664,0, нийт 49335,2 сая төгрөг авахаас бүрэн авсан байна. Санхүү, төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулж, өр авлага барагдуулах талаар гарсан аймгийн Засаг даргын 2016 оны 07 дугаар “Албан даалгавар”, зарлага, санхүүжилтыг хугацаанд нь гаргах, хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, оны эцэст аймаг, сумын хэмжээнд өргүй гарах арга хэмжээ авч сум, байгууллагуудад байнга үүрэг чиглэл өгч ажиллав.

Энэ ажлын хүрээнд төсвийн боломжит эх үүсвэрүүдийг удирдаж, аймгийн Засаг даргын 2016 оны А/588, А/589, А/610 дугаар захирамжаар төсвийн зарим орлого өндөр төсөвлөгдсөнөөс тасарч, зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдаж өртэй байгаа сум, байгууллагуудад 167,0 сая, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тогтмол зардал хүрэлцэхгүй өртэй байгаа 9 байгууллагад 16,7 сая төгрөгийг аймгийн төсвийн хэмнэлтээс, боловсролын салбарын төсвийн багц дотор нь 104,5 сая, төсвийн шууд захирагчдын батлагдсан төсвийн зардал хооронд зохицуулалт хийх шийдвэрийн дагуу аймгийн төвийн болон сумын 7 орон нутгийн төсөвт байгууллагад 46.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн 29 байгууллагад 119.6 сая төгрөгийн зохицуулалт хийж өр, авлага үүсч байсныг бууруулан ажиллав. Өр барагдуулах талаар аймгийн ТЕЗ төсөвт зохицуулалт хийж ажилласны дүнд өмнөх оноос буурч 65,0 орчим сая төгрөгийн өртэй гарав.

Улс, орон нутгийн төсвийн болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, гүйцэтгэгч компаниудын хариуцлагыг сайжруулж, ажлыг гэрээт хугацаандаа дуусгах, дуусгаагүй бол алданги тооцох, хяналтын

зардлыг тооцох, баталгаат хугацааны мөнгө байршуулах, уг ажлын зураг, төсвийн мөнгийг суутган тооцох зэрэгт анхаарч санхүүжилтүүдийг олгов.

Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан 2017 оны төсвийн нэгтгэлийг сум, байгууллага, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар төсвийн шинэчилсэн Фискал програмд шивж, баазыг цахимаар болон цаасаар аймгийн Засаг даргын албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэв. Орон нутгийн төсвийн 2017 оны төлөвлөгөө, түүний сар, улирлын хуваарийг төсвийн төлөвлөлтийн мэдээллийн шинэ системд оруулах ажлыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 12 дугаар сарын 3/7473 дугаар албан бичгийн дагуу 2017 оны 1 дүгээр сарын 4-17-ны хооронд аймаг бүр хуваарийн дагуу зохион байгуулж, төсвийн төлөвлөгөө оруулах үйл явцын талаар Сангийн яамны аймаг хариуцсан мэргэжилтэнд мэдээлж танилцуулан хамтран ажиллаж байна. Орон нутгийн 2017 оны төсвийн төлөвлөгөөг олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэх үүднээс аймгийн болон шилэн дансны вэб сайтад хуулийн хугацаанд байршуулж мэдээлэв. Сум, байгууллагуудад 2016 оны жилийн эцсийн тайлан гаргах, тайлангийн нэгтгэл хийх, тушаах талаар хэлтсийн даргын 64, 137 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлэв.

Төрийн сангийн нэгжүүдийн үйл ажиллагааны эрсдлийн үнэлгээг хийж, 2017 оны төлөвлөгөөт хяналтыг аймгийн Засаг даргын А/09 дугаар захирамжаар төлөвлөж, төрийн сангийн ажилтны шинэчилсэн судалгаа, Төрийн сангийн нэгжүүдийн тамга, тэмдэгийн бүртгэлийг хийж, албан бичиг, тамга, тэмдэгийн хэвний хамт Сангийн яаманд албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем дэх Булган, Дарви, Дөргөн сумын 1 дүгээр хэрэглэгч, Үенч сумын 2 дугаар хэрэглэгчийн эрхийг Сангийн яаманд албан тоот хүргүүлэн нээлгэж, төрийн сангийн үйл ажиллагааг хэвийн ажиллах нөхцлийг хангав.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд ашиглагдаж байгаа 703 дансны ангиллыг хийж, Олон Улсын IBAN системд нийцүүлж 100 гэсэн дугаарлалт дансны өмнө хийгдсэнтэй холбоотойгоор сум, байгууллагуудад албан бичиг хүргүүлж, гарын үсгийн баталгааг шинэчлэн ажиллаж байна. Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем дэх хэрэглэгчийн хөдөлгөөний тайланг Сангийн яаманд хүргүүлж, хянуулан хэрэглэгч зөрүүтэй зөрчлийг арилгуулан ажиллаж байна.

Аймгийн мал тооллогын ажлын урьдчилсан дүнгийн танилцуулгыг гаргаж, аймгийн удирдлагуудад тараав. Ажиллах хүчний судалгааг Цэцэг, Дөргөн, Жаргалант сумын 36 өрх, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Булган, Манхан, Жаргалант сумын 26 өрхөд хийж, судалгааны материал шивэх ажлыг хийж байна.

Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны 2 дахь шатны судалгааг улсын хэмжээнд 2 дугаар сарын 13-24-нд зохион байгуулах гэж байгаатай холбогдуулан хамрах хүрээг тогтоохоор Булган, Үенч, Алтай, Цэцэг сумдын төрийн сангуудтай холбогдон тодруулга хийж, заагдсан хугацаанд тухайн сумын орд газруудад цас их унасан учраас бичил уурхай эрхлэгчид нэмэгдэхгүй гэсэн хариултыг ҮСХ-нд хүргүүлсэн. Жилийн эцсийн 39 төрлийн мэдээг аж ахуйн нэгжүүдээс гаргуулан авч програмын дагуу графикт хугацаанд нь алдаагүй, хоцрогдолгүй ҮСХ-нд дамжуулж ажиллав.

**Гурав. Хууль эрх зүйн салбарын хүрээнд:** Шинээр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 3 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, 2 албан тушаалтны мэдүүлэг хянагдаж, 2 албан тушаалтны ХАСХОМ-ийг цахим сүлжээнд шивж цаасан бүртгэл хийв. 2016 оны ХАСХОМ-ийг

аймгийн хэмжээнд нийт 280 албан тушаалтан гаргахаас одоогийн байдлаар 136 албан тушаалтан мэдүүлгээ шинэчлэн гаргасан байна. Аймгийн Засаг даргын захирамжийн төсөлд өгөх визний хуудасны загварыг шинэчлэн Тамгын газрын даргын тушаалаар батлуулж сум, байгууллагуудад хүргүүлэв. Сумдын Засаг даргын захирамж, төсвийн ерөнхийлөн захирагч нарын тушаалуудыг хянах график гарган хүргүүлж эхний 2 сумын захирамж, тушаалыг хүлээн авч хянаж байна. Мөн Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх зорилгоор захиргааны шийдвэрийн хувийн хэрэг, хяналтын хуудас, баримтын загварыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/13 дугаар тушаалаар баталж, төсвийн байгууллагын захирагч нарт уг тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Архивын баримтыг цахимжуулах ажлын хүрээнд 3 хөмрөгийн 3 дансны 1964-1990 оны 46 ширхэг хадгаламжийн нэгж буюу 6696 хуудсыг данс, бүртгэлийн хамт цахим хэлбэрт оруулав. Энэ сард 95 хүн архивын лавлагаа магадлагаа хүссэнээс цалингийн тодорхойлолт 27 хүнд, тогтоол, захирамж, тушаалын лавлагааг 32 хүнд, архиваас холбогдох баримт олдоогүй гэсэн лавлагааг 36 хүнд олгов. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг сонгох сонгуулийн 1205-1296 дахь хэсгүүдийн 25 хайрцаг буюу 51701 ширхэг битүүмжилсэн саналын хуудсыг бүртгэлээр хүлээн авч нөхөн бүрдүүлэлт хийв.

**Цагдаагийн газар:** Ховд аймгийн хэмжээнд 2017 оны 01 дүгээр сарын 25-ны байдлаар 36 гэмт хэрэг бүртгэгдсэнээс төрлөөр нь ангилан үзвэл бусдын бие махбодид гэмтэл учруулах 12, хулгайлах 14, үүнээс иргэдийн 7, малын хулгай 7, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 4, танхайрсан гэмт хэрэг 1, байгаль хамгаалах журмын эсрэг 1, бусад 4 хэрэг бүртгэгдсэн байна. Цагдаагийн газар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 392 гомдол мэдээлэл хүлээн авсанаас 121 буюу 30.8 хувийг гэмт хэргийн талаарх, 257 буюу 65.5 хувь нь захиргааны зөрчлийн талаарх, 14 буюу 3.5 хувийг бусад гомдол эзэлж байна. Зөрчил гаргасан 100 хүнийг албадан саатуулж, 1358 хүнийг 89.433.400 төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажиллав.

**Шүүхийн шинжилгээний алба:** Тус алба нь 2016-2017 оны сургалт болон соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу 6 сэдвээр 8 цагийн сургалт, спорт, цасны баярын арга хэмжээг тус тус зохион байгуулж, алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон үр дүнтэй өнгөрүүлэв. Мөн хууль сахиулах байгууллагуудын хамтарсан зөвлөгөөнд нийт бүрэлдэхүүнийг оролцуулж санал, бодлоо солилцов.

Албаны үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой мэдээлэл ирээгүй бөгөөд нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэхээр 1 өргөдөл ирүүлснийг хүлээн авч хариуг албан бичгээр өгч шийдвэрлэв. Алба хаагчдын цалинд 11,325,000 төгрөг зарцуулж, төлбөрт үйлчилгээний орлогод 411500 төгрөг төвлөрүүлэв.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба:** Тус алба нь нийт нийт 64 албан хаагчийн орон тоо, цалингийн сантайгаас 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар хүний нөөц сургалт мэдээлэл хариуцсан мэргэжилтэн 1, шийдвэр гүйцэтгэгч 2, хянагч 1, хүний тоо бүртгэлийн туслах ажилтан 1, нийт 5 албан хаагчийн орон тоо дутуу 59 алба хаагчтай ажиллаж байна. Алба хаагчдын ажлын цаг ашиглалтанд хяналт тавьж ажилласны зэрэгцээ 7 хоногийн Даваа, Баасан гарагт нийт бүрэлдэхүүнийг сургалт жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт нь арилгуулан ажиллав.

Хорих ангийн харуул хамгаалалтыг “Хорих ангийн харуул хамгаалалт болон ялтанд хяналт тавих журам”-ын дагуу хэвийн явагдаж, албаны даргын тушаалаар онцгой үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын

үйл ажиллагаандаа мөрдөн, болзошгүй ажиллагааны үед ашиглагдах Тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад өдөр бүр бичгээр үүрэг даалгавар өгч, биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Тус хэлтэс нь энэ сард нийт 3290 иргэнд үйлчилгээ үзүүлснээс Иргэний бүртгэлийн чиглэлээр 2094, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 766, шилжин ирсэн иргэд 72, шилжин явсан иргэд 167, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 527, гадаад паспорт олголт болон сунгалт 228, иргэний үнэмлэх шинээр олгосон 186, сунгалт 133, дахин олгосон 64, иргэний бүртгэлийн лавлагаа 488 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 229 бүртгэлийг хийв. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 1058, хуулийн этгээд, бүртгэлийн чиглэлээр 114 иргэнд холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав. Иргэдээс нийт 24 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 20 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 2 өргөдлийг холбогдох байгууллагад шилжүүлсэн бол, 2 өргөдлийн хугацаа болоогүй байна.

#### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн салбарын хүрээнд:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь салбарын хүрээнд иргэдийн бүтээлч оролцоог өргөжүүлэх, нийгмийн үйлчилгээг иргэд тэгш авах боломжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэн салбарын чиглэлийн үндэсний 27 хөтөлбөрийг хэрэгжүүлэн, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 16 дэд хөтөлбөрийг 2017 оны 01 дүгээр улиралд боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөн, бэлтгэл ажлыг хангав.

Оны эхэнд салбар агентлагуудын дарга нарын үр дүнгийн гэрээг дүгнэж, Засаг даргаар үнэлүүлэн харьяа яамдуудад хугацаанд нь хүргүүлж, сумдын Засаг дарга нартай байгуулах гэрээний төслийг бэлтгэн, хэлтсийн 13 хавтас материалыг архивын тасагт өгч, 2017 онд хийх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, нийгмийн салбарт хийгдэх томоохон арга хэмжээг нэгтгэн, аймгийн Засаг даргын Тамгын газрын календарьчилсан төлөвлөгөөнд тусган хэрэгжилтэнд хяналт тавин ажиллав.

Боловсрол соёл шинжлэх ухааны яамны сайдын тушаалаар батлагдсан Ховд их сургуулийн удирдах зөвлөлийн гишүүнээр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Боловсрол шинжлэх ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн нар томилогдон тус сургуулийн 2016 оны тайлан, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн 2017 оны төсвийн төслийг баталлаа.

Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсгийг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга ахлан аймгийн Хөгжимт драмын театрт 2 өдөр ажиллаж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийв. Аймгийн Засаг даргын Б/11 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга ахлан аймгийн Хөгжимт драмын театрын дарга М.Баатарын ажлыг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон Д.Гантуяад хүлээлгэн өгөв.

**Боловсрол, шинжлэх ухааны талаар:** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон Ховд аймгийн Засаг даргын хооронд 2016 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний ажил үйлчилгээг гүйцэтгэлээр нь тооцож 93,66 хувийн үнэлгээтэйгээр дүгнэн холбогдох яам, газруудад хүргүүлэв.

Олон нийтийн оролцоот загвар сургууль бий болгох зорилгоор аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Монгол улсад Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь төсөлтэй хамтран 8 сумын 10 сургуулийн төлөөллийг оролцуулан 2 өдрийн сургалтыг зохион байгуулав.

**Соёл урлаг, спортын талаар:** Соёл урлаг спортын салбарт хэрэгжиж буй үндэсний 7 хөтөлбөрийн тайланг гарган холбогдох газруудад хүргүүлж, биеийн тамир спортын газрын даргын 2017 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөөг хянан батлуулж, гэрээ байгуулав.

Мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Спортын аварга” хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Олимп, тив, дэлхий, улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулах журмыг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулахад бэлэн болгов.

“Олон үндэстэн ястны өв соёл” хөтөлбөр, Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын дурсгалыг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан иргэд, өвлөн уламжлагчдыг урамшуулах журмыг боловсруулах, Монгол туулийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Их өргөөнд “Наран хөвүүн хаан” туулийг бүрэн хэмжээгээр хайлах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Соёл урлагийн салбарын статистик үзүүлэлтүүд болон хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг гаргахаар төлөвлөн, судалгаа, тайлан мэдээг нэгтгэн судалгааны ажлыг эхлүүлж, салбарын сургалтын хөтөлбөр, стратеги төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.

Соёл олон нийтийн ажлын хүрээнд Хөгжимт драмын театрын уран сайхны удирдаач, ерөнхий хормейстр Х.Эрхэмбаяр, хөгжимчин Б.Булганбат нарын бие даасан тайлан тоглолт, олон нийтийг хамарсан 8 арга хэмжээг зохион байгуулав.

Нийтийн номын сангаар үйлчлүүлсэн 257 уншигчдад карт нээж 2661 ирцэд 1540 ном, сонин хэвлэл олгон, 5 удаагийн номын үзэсгэлэн гарган, ерөнхий боловсролын 1 дүгээр сургуультай хамтран “Нээлттэй хаалганы өдөр”, БСШУСЯ-ны “Соёлын өвийн төв”-ийн Монгол туулийн цоморлиг цувралын XII боть “Алтайн урианхай Занын Жилкэрийн удмын туульчид” шинэ номын нээлтийн үйл ажиллагааг тус тус зохион байгуулав.

Мөн Жаргалант сумын 8 дугаар цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхэд, багачуудад “Монгол үндэсний хувцас” сэдвээр соёл хүмүүжлийн ажил, соёлын биет бус өв тээгчид болон сум орон нутгийн хамгаалалтанд авах түүх соёлын дурсгалын судалгаануудыг гарган, 2017 онд хийгдэх Соёлын биет бус өвийн цахим сан бүрдүүлэх ажлын бэлтгэлийг ханган, 2 дугаар сараас эхлэн бүртгэн баримтжуулалтыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Тайлант сард Үндэсний, Жүдо, Чөлөөт, Самбо бөх, Бокс, Таеквондо, Волейбол, Сагсан бөмбөг, Хөнгөн атлетик зэрэг спортын төрлүүдээр 550 гаруй тамирчин, хүүхдүүд бэлтгэл сургуулилтанд хамруулж байна.

Аймгийн Биеийн тамир спортын газрын түүхт 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Сагсан бөмбөгийн насанд хүрэгчдийн “Аймгийн аварга шалгаруулах тэмцээн”, УБ хот дахь нутгийн зөвлөлийн дэргэдэх “Ховдын түүчээ” оюутан залуучуудын холбооноос санаачлан зорилтот бүлгийн иргэдэд туслах “Сайн үйлс дэлгэрэг” хүмүүнлэгийн аяныг өрнүүлж

идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнийг амжилттай зохион байгуулав.

БНХАУ-ын Алтай аймагт зохион байгуулагдсан Олон улсын цас мөсний баярт Монгол улс Ховд аймгаа төлөөлөн оролцож тамирчин Ө.Тогтохсүрэн тэшүүрийн спортоор 500м зайд хүрэл медаль, 1500м зайд мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүллээ. Энэхүү олон улсын цас мөсний баярт Ховд аймгаас 15 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид оролцов.

2017 оны 01 дүгээр сарын 29-ээс 2 дугаар сарын 03-ны өдрүүдэд Самбо, Жүдо, Чөлөөт бөхийн чуулга барилдаан, аймгийн аварга шалгаруулах хүүхдийн спортын бага наадмыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

**Эрүүл мэндийн талаар:** Улирлын чанартай томуу, томуу төст өвчин дэгдэлт хэлбэрээр гарсантай холбогдуулж Засгийн газрын 215 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор сум, өрхийн Эрүүл мэндийн төвийг уртасгасан цагаар ажиллуулах, эрүүл мэндийн хяналтыг гэрийн эргэлтийн тогтолцоонд шилжүүлэх, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 08 дугаар тогтоолын дагуу 5 хүртэлх насны хүүхдүүдэд эмийн хөнгөлөлтийг жагсаалтын дагуу олгуулах арга хэмжээг авав. Томуугийн өвчлөлийн тандалтыг өдөр бүр нэгтгэн дүгнэж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүүхдийн тасгийн үйл ажиллагаатай 2 удаа танилцаж, тандалт мэдээллийн судалгааг үндэслэн Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яаманд албан тоот хүргүүлж, аймгийн Засаг даргын Захирамжаар сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 7 хоногийн хугацаатай хааж, өвчний дэгдэлтийг бууруулах арга хэмжээг авснаар 2017 оны 1 сарын 25-ны байдлаар амбулаторын нийт үзлэгт томуугийн эзлэх хувь 11.7 болж буурсан дүнтэй байна.

Томуугийн өвчлөлтэй холбоотойгоор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Томуугийн тандалт судалгааны албаны дарга, холбогдох хүмүүсийн хамт Ховд аймагт ажиллаж томуугийн дэгдэлт, цаашид сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар өрх, сумуудад ажиллан заавар зөвлөмж өгч, сургуулийн эмч, өрх, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн холбогдох мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, бага насны хүүхдийн 240 тун тамифлю эмийг олгож, томуугийн вакциныг Ховд аймагт хуваарилан ирэх 7 хоногоос нийлүүлэхээр шийдвэрлэв.

Эрүүл мэндийн чиглэлээр Засгийн газрын тогтоолоор батлагдсан 12 үндэсний хөтөлбөр, 6 стратеги, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн Эрүүл мэндийн талаар тусгагдсан нийт 75 заалтаас орон нутагт хамааралтай 49 заалтын биелэлтийг тооцож хүргүүлэв.

1 дүгээр сард сумдын эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг мэргэжлийн болон санхүүгийн удирдлагаар хангах үүрэг бүхий Удирдах зөвлөл, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг аймгийн хэмжээнд зохицуулах чиг үүрэг бүхий “Эрүүл мэндийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн боловсруулж Засаг даргын Захирамж гаргуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар үүрэг чиглэл өгөв.

Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн шийдвэрийн дагуу “Эхийн эндэгдэл, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл”-ийн талаар зохион байгуулсан арга хэмжээний тайланг Эрүүл мэндийн газрын дэргэдэх эх, хүүхэд, нярайн эндэгдлийг магадлан хэлэлцэх багийн гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн Эрүүл мэндийн яаманд, Эрүүл насжилт, настны эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн мэдээллийг бэлтгэж Эрүүл мэндийн яамны харьяа Геронтологийн үндэсний төвд тус тус заасан хугацаанд нь хүргүүлэв.

БОЭТ, сумын Эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, Нэгдсэн эмнэлгүүдийн 2017 онд хэвтэн эмчлүүлэгсдийн эмчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн эмийн тендэрийг зарлаж нийт 18 эм ханган нийлүүлэх байгууллага саналаа ирүүлснээс 13 байгууллага шалгарч 1256,5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэхээр гэрээ хийв. Энэ нь өмнөх онд нийт эмийн 61.8 хувьд тендэр зарлагдаж байсантай харьцуулахад 86.1 хувьд хүрч, өмнөх оныхоос 24.3 хувиар өсч, эмийг 1 дүгээр сарын 20-ны өдрөөс нийлүүлж эхлэв. Монгол Улсын хүний гавьяат эмч, АУ-ны доктор, клиникийн профессор, ЭХЭМҮТ-ийн нүдний мэс заслын тасгийн зөвлөх эмч М.Алтанхүүгээр ахлуулсан Орбис төслийн баг нүдний хугарлын өөрчлөлтийг эрт илрүүлэх, оношлох, үнэ төлбөргүй нүдний шилээр хангах зорилгоор манай аймагт ажиллаж амьжиргааны түвшингийн 1-5 бүлгийн өрхийн хүүхдүүдийн 30 хувьд нүдний шил олгож төслийг хэрэгжүүлэхээр боллоо.

**Хөдөлмөр нийгмийн хамгаалалын чиглэлээр:** Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан төрийн байгууллага болон эцэг эх, иргэдийн төлөөлөл нийт 60 хүнийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулав. Аймгийн “Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих”, “Зөв хөдөлмөрч залуу”, “Ахмадаа ачлая” дэд хөтөлбөрүүдийн төслийг боловсруулж байна. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд “Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийг чадавхижуулах” сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Ажил олгогч эздийн холбоотой хамтран зохион байгуулав. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тайланг гаргаж холбогдох яаманд хүргүүлээд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 2 удаа хуралдуулж 19 хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тохирох үйлчилгээнд хамруулав.

Монгол улсын Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын А/319, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/11 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн даргын А/01 тушаалаар аян зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах, одоо авч байгаа хэмжээг баталгаажуулах тэтгэвэр авагчдаас гаргасан өргөдөл, хүсэлтийг хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** Аймгийн ХХААГазрын 2016 оны жилийн эцсийн тайлан, мэдээ, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, Сайдын болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу арьс, шир бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан 17 сумын малчин, мал бүхий иргэдийн материалыг хүлээн авч Мал хамгаалах санд хүргүүлэх бэлтгэл ажлыг хангав. Аймгийн хошой аварга малчин, аварга малчин, саальчин, фермер, тариаланч, тариаланч хамт олон шалгаруулах журмыг шинэчлэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна.

Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүдийн болон малчдаас авах дэлгэрэнгүй судалгааг малчин нэг бүрээр гаргаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэв. Энэ онд 3280,6 мянган мал /үүнээс тэмээ 23,9 мянга, адуу 122,7 мянга, үхэр 182,0 мянга, хонь 1266,0 мянга, ямаа 1685,8 мянга/ хонин толгойд шилжүүлснээр 4,8 сая мал өвөлжиж байна.

Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн үйлчилгээний 53 нэгжид малын их эмч 41, малын бага эмч 26, мал зүйч 4 нийт 71 мэргэжилтэн, МЭҮТ-17 мэргэжилтэн, Мал эмнэлгийн үйлчилгээний нэг нэгжид 64,1 мянган мал, малын эмч тус бүрт 50,7 мянган мал ногдож 3.2 сая



гаруй мал сүргийн эрүүл мэндийг хамгаалан элдэв өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж цаашид түүнтэй тэмцэх бодлого боловсруулан ажиллаж байна. Мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2018 онд хамрагдах мал, түүнд шаардагдах био бэлдмэл, төсөвт зардлын тооцоог сумын МЭҮН-ээс ирүүлсэн санал, захиалга, өвчний гаралт, тархалтын судалгааг нэгтгэн УМЭҮГ-т хүргүүлэв.

2016 оны 12 дугаар сарын 23-нд Дарви сумын Мөнгөн аяга багийн нутаг Баянцагааны нуруунд бөхөн хэд хэдээрээ үхсэн мэдээллийг байгаль хамгаалагч Ш.Дэмбэрэлдовдон аймгийн БОАЖГ-т өгч МЭХ-ийн дарга, ийлдэс судлаач эмчийн хамтаар газар дээр нь очиж дээжийг шинжилгээнд хамруулахад УМЭАЦТЛ-ийн 2017 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 17-99 дугаар бүхий сорилтын дүнгээр өвчний вирусын генийн хэсэг болон эсрэг төрөгч илэрч онош бог малын мялзан өвчин болох нь тогтоогдсон.

2017 оны 1 сарын 25-ны байдлаар Дарви, Чандмань сумын нийлбэр дүнгээр **1173** бөхөн, **21** хар сүүлтийн сэг зэмийг устгалд орууллаа.

Батлагдсан оношийн дагуу 2017 оны 01 дугаар сарын 03-нд аймгийн онцгой комисс ДБХ сан, МЭАЦТЛ, ХХААГазар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ХУНОУТХГНХЗ, Мэргэжлийн хяналтын газар, сумдын удирдлагуудыг оролцуулсан ажлын хэсэг Дарви, Чандмань сумдын малчид, мал бүхий иргэд сумын холбогдох мэргэжилтнүүдэд Бог малын мялзан өвчинтэй хэрхэн тэмцэх, зааврыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгч, үхэж хорогдсон бөхөнг устгаж, халдваргүйтгэх, дээж авах, тандалт судалгаа хийж ажиллав.

**Үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр:** ХХААХҮЯ-наас газар тариалангийн үйлдвэрлэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны үндсэн чиглэлд тусгагдсан газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр ХХААГ-ын 2017 оны үйл ажиллагааны календарьчилсан төлөвлөгөөнд саналаа тусгаж хамтран ажиллав.

Дэлхийн зөн олон улсын байгууллагын Ховд салбарын зорилтот бүлгийн 300 өрхөд газар тариалангийн шинэчлэгдсэн хууль сурталчлах сургалтыг зохион байгуулав.

**Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлээр 2011-2016 онд нийт 6.2 тэрбум төгрөгийн 1099 төсөл хэрэгжиж шинээр 1279 ажлын байр бий болж, 1011 ажлын байр хадгалагдсан байна. Үүнээс 2016 онд 623.3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 129 төсөлд олгож 137 ажлын байр шинээр бий болж, 113 ажлын байр хадгалагдаж, нийт хэрэгжиж байгаа төслүүдийн 1843.5 сая төгрөгийн 320 төсөл зээлийн хугацаа хэтрэлттэй байна. Аймгийн хүнсний үйлдвэр, цехийн суурилагдсан хүчин чадал, түүний ашиглалт, хөдөө аж ахуйн гаралтай хүнсний түүхий эдийн нөөцийн судалгааг сум бүрээр шинэчлэн гаргаж, ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-т хүргүүлэв.**

Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор малчдын мал, махыг боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжид худалдах үйл ажиллагаанд хэрхэн хамрагдах талаар аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгч, Дэлхийн Зөн ОУБ-ын салбартай хамтарч, “Хүнсний аюулгүй байдал” сургалт зохион байгуулж Жаргалант сумын 6 багийн 100 гаруй иргэн оролцов.

**Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:** 2016 оны жилийн эцсийн тайлан, гэрээний биелэлтийг цахим болон цаасаар холбогдох байгууллагуудад хүргүүлэв. 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр “Богч констракшн” ХХК-ийн 12 айл, “Хан орд” ХХК-ийн 12 айлын орон сууцны барилгуудад улсын комисс ажиллаж барилгыг ашиглалтанд хүлээн авлаа.

**Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** Дарви сумын Мөнгөн аяга багийн нутаг Баянцагааны нуруунд 2016 оны 12 дугаар сарын 23-нд бөхөн хэд хэдээрээ үхсэн тухай мэдээлэл ирсний дагуу аймгийн онцгой комиссын ажлын хэсгийн багийнхантай хамтран ажиллав. Бөхөнгийн сэг зэмд хийсэн үзлэг, задлан шинжилгээ, өвчний шинж тэмдэг, эмгэг хувиралт зэргийг үндэслэн бог малын мялзан өвчин гэж урьдчилан оношлож, онош баталгаажуулах зорилгоор дээжийг УМЭАЦТЛ-д хүргүүлж мялзан өвчний шинжилгээ хийлгэв.

УМЭАЦТЛ-ийн 2017 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 17-99 дугаар бүхий сорилтын дүнгээр уг дээжинд /уушиг, элэг, дэлүү, бөөр, нуух / Бог малын мялзан өвчний вирусын генийн хэсэг болон эсрэг төрөгч илэрч онош батлагдсан.

Дарви сум: Баянцагааны чиглэл /Мөнгөн аяга баг “Элс толгой”/-ийн устгалын цэгт 558 бөхөн, үүнээс 19 хар сүүлтийн сэг зэм, Далан түрүүний говь чиглэл /Булаг баг “Тайны тохой”/-ийн устгалын цэгт 165 толгой бөхөн, нийт 723 сэг зэмээс 704 бөхөн, 19 хар сүүлтийн сэг зэмийг тус тус устгаад байна.

Чандмань сум: Тахилт баг “Тэсгэний үзүүр” устгалын цэгт 243 бөхөн, Баянхайрхан баг “Нурамт” устгалын цэгт 146 бөхөн, нийт 389 бөхөнгөөс 287 бөхөн, 2 хар сүүлтийг устгаж, сумдын нийлбэр дүнгээр **1112** сэг зэм устгаснаас 1091 бөхөн, 21 хар сүүлтийн сэг зэмийг устгав. /ХХААГ, БОАЖГ тоо зөрөөд байна./

Үхсэн бөхөнгийн 60%-ийг янзага буюу төл, 30%-ийг шаргачин буюу эм, 10%-ийг ооно буюу эр эзэлж байна.

Өвчин цаашид нэлээд тархаж өвчлөл, үхэл хорогдол ихсэх хандлагатай тул үхсэн бөхөнгийн сэгийг устгах, халдваргүйжүүлэх, малчид иргэдэд мэдээ мэдээлэл хүргүүлэх зэрэг ажлыг орон нутгийн байгаль орчны болон холбогдох мэргэжлийн байгууллагууд тухайн сумуудын төр захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна.

Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн хавцлын мушгуйн аманд янгирын тэх хамуурч үхсэн байсныг дээж авч устгав.

Алтай сумын Майхан хард хууль бус алт олборлолт явагдаж буй мэдээллийн дагуу хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй, Ховд сумын Хогийн худаг хэмээх газарт байгаль хамгаалагч, Байгаль орчны байцаагчтай хамтран хууль бусаар алт олборлож байсан иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоож хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаа.

Улсын их хурлаас 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу Жаргалант сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Ховдын өргөө” ХХК-ний “Хөнгөн блокны үйлдвэр”, “Вестерн холд” ХХК-ний “Богийн арьс, бодын шир бүрэн боловсруулах үйлдвэр” байгуулах төслүүдийг судалж үзэхэд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хавсралт болон “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хандах шаардлагатай тул хүсэлт ирүүлсэн байгууллагуудад хариу хүргүүллээ.

“Адуучин” тэмцээнийг Буянт, Мянгад, Дөргөн, Чандмань, Увс аймгийн Өлгий, Өмнөговь, Завхан сумдын адуучин залуучуудыг оролцуулж авхаалж самбааг сорьсон уралдаан тэмцээнийг 3 дахь жилдээ зохион байгуулж хэвшээд байна.

Мянгад сумын байгаль хамгаалагч хүүхэд залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд нь зориулж цэцэрлэгт хүрээлэнгийн элсний хөл бөмбөгийн талбайг хоккей тоглох мөсөн талбай болгон тохижуулав.

Цэцэг сумын ЗДТГ, Оюутны холбоо, Дуут сумын Цагаанбургас багийн “Агуйт” бэлчээр ашиглагчдын хэсэгтэй хамтран аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор “Мөнгөлөг Цэцэгчүүд”

цас мөсний баярыг өргөн хүрээтэй зохион байгуулж, албан байгууллага, ААН, баг хамт олон нийт 150 гаруй иргэд идэвхи санаачлагатай оролцов.

Аймгийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сайжруулсан утаа бага гаргаж иргэдийн эдийн засагт хэмнэлттэй Векас-801, 107, 108 зуухны үлдэгдэл 50 хувийг иргэдэд олгох ажлын хэсэг байгуулагдан Байгаль орчин, аялал жуулчлалын яам, агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өгөгдсөн чиглэл зааврын дагуу ажиллаж холбогдох баримт, материалыг бүрдүүлж байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлэв.

Үенч, Мөнхайрхан сумын байгаль хамгаалагч нар хамтран Үенчийн хавцал, Цагаан чулуут, Жаргалан зэрэг газруудад зэрлэг амьтны мониторинг судалгаа, хяналт шалгалт хийж 46 янгир ямаа, 12 тэх тоолж, Жаргалан уулын аманд 200 кг давс ан амьтанд зориулан тавив.

Мянгад сумын байгаль хамгаалагч, байцаагч нар хамтран 8-10-ны өдрүүдэд Ховд голын сав дагуу Гахайт багийн нутаг дэвсгэр Гангын арал, Их булангийн тохой, Жонжоо, Оролмаа маршрутаар хяналт шалгалт хийж Гахайт багийн нутаг дэвсгэр Гангын арлаас хашаа барих зориулалтаар бэлтгэсэн нойтон бургасыг хураан эзэн холбогдогчийг тогтоож, Их булангын аралаас гэрийн мод хийх зориулалтаар бэлтгэсэн 250 ширхэг модыг хураан сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөв.

Эрдэнэбүрэн сумын байгаль хамгаалагчид хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Ховд голын улиас, бургас бүхий арлууд, Булжимын шил, Бор модны арал, Улаан харгана, Ямаат улаан, Шургийн гол 24 айл өрх, 52 иргэдтэй уулзан байгаль орчныг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгч санал хүсэлтийг авч ажиллав.

#### **Зургаа. Сумдын мэдээлэл:**

**Алтай сум:** Аймаг, сумдын нутгийн зөвлөлүүдийн хүч, нөөц бололцоог дайчлан, хандив хөрөнгө санхүүгийн дэмжлэг авах ажлыг зохион байгуулж өвөлжилт хүндэрсэн баруун 3 сумын малчдад Цаст–Алтайн Жинчид ХХК-ны жолооч нараас 750 боодол өвсийг хандивлав. Аймгийн нийгмийн бодлогын асуудал хариуцсан Засаг даргын орлогч Ч.Уранчимэгээр ахлуулсан ажлын хэсэг сумын төсөвт байгууллага болох Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйл ажиллагаа үзүүлж цаашид хэрхэн яаж ажиллах талаар үүрэг чиглэл өгөв.

Шинэ үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойн баярыг угтаж Хавтаг, хилийн зурвас газар болох Тахийн шар нурууны чиглэлд өвөлжиж буй 100 гаруй малчид, хилийн 6,7 дугаар заставуудад “Захчин түмний буян заяа” төрийн бус байгууллага, сумын ИТХ, ЗДТГ хамтарч урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулав.

Эрүүл мэндийн төв эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын шаардлагыг хангах зорилгоор хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй чанартай үзүүлж, сумын хүн амын нас баралт, өвчлөлийг бууруулан эмнэлгийн үндсэн үзүүлэлтийг улс, аймгийн түвшинд хүргэж, 2017 оныг “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон ажиллаж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын эрүүл мэндийн төвд нэн шаардагдах Центрфуг -1ш, хүчилтөрөгч өтгөрүүлэгч-1ш, Пульсоксилер-4ш Автоклав 1ш –ийг 5500000 төгрөгөөр худалдан авч хөрөнгө оруулалт хийв.

**Дөргөн сум:** Монгол улсын Засгийн газрын 122 дугаар тогтоолоор малчин, мал бүхий этгээдийн арьс ширний баримтыг шивж 350 ширхэг баримтыг 6139 арьс шир бүртгэв. ЕБС-д үдийн цай нийлүүлэх тендер шалгаруулалтыг 01 сарын 10 –нд зохион явуулж 2 аж ахуйн нэгж

материал ирүүлснээс “Тээлийн буян” БГБХН ажлын 5 өдрийн 2 өдөрт нь, болж, Дөргөн нутгийн хишиг БГБХН ажлын 5 өдрийн 3 өдөрт нь нийлүүлэхээр шалгарлаа.

Мал амьтны гоц халдварт мялзан өвчин гарч улмаар нэн ховор бөхөн их хэмжээгээр хорогдсон учир сэг зэм устгах, ариутгал халдваргүйжүүлэлт, самналт хийх ажлын хэсэг байгуулан нийт 14 бөхөнгийн сэг зэмийг устгаж ариутгал хийв.

**Дарви сум:** Тус сум нь шинэ ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан ЗДТГ, сумын залуучуудын холбоотой хамтран хүүхэд залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий “Иргэний андгай өргөх ёслол”, монголчуудын өв соёлын нэг болсон үндэсний 32 бөхийн барилдаан зохион байгуулж 200 гаруй хүн үзэж сонирхов.

Мөн сумын алдартнуудыг алдаршуулах, хойч үед нь таниулах үлгэр дуурайл болгох зорилгоор “Алдартнуудыг танилцуулах танин мэдэхүйн тэмцээн”, Алдартнуудын лавлагаа цахим сан бүрдүүлэх ажлыг эхлүүлэн, ОНСТ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулав.

Сумын номын сан 2017 оны ажлаа төлөвлөн, 100 гаруй номыг цахимд оруулж, 120 уншигчдад, 236 ширхэг номыг гэрээр болон танхимаар олгож, номын сангаар өдөр бүр 30 гаруй хүүхэд залуучууд тогтмол үйлчлүүлж байна. “Орон нутгийн хөгжилд ТББ-уудын оролцоог нэмэгдэхүүлэх нь” сэдэвт сумын хэмжээний сургалтанд байгууллагын төслийн баг хамрагдан 2 төслийг ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагад хүлээлгэн өгөв.

Сумын хүн эмнэлэг энэ сард урьдчилан сэргийлэх үзлэгээр 120, гэрийн идэвхитэй эргэлт 304, диспансерийн үзлэг 49, гэрийн дуудлага 118, өвчний учир 118 нийт 777 иргэнд эрүүл мэндийн болон эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлэв. Амбулаторийн үзлэгт хамрагдсан 370 иргэнээс томуугийн өвчлөлтэй 132 иргэн байв. Томуугийн өвчлөл дэгдэлт ихэсч буйтай холбогдуулан 0-5 насны хүүхдийн эмийн үнийг хөнгөлөлттэй жороор олгох эрүүл мэндийн Сайдын тушаалын дагуу нийт 79 хүүхдэд үнэгүй эм тарааж, 500.000 төгрөг зарцуулав. Энэ сард эмнэлэгийн хүнсэнд 470000 төгрөг, бараа материалд 2346000 төгрөг зарцуулсан байна.

**Ховд сум:** Тус сумын Засаг даргын Тамгын газар нийт 14 өргөдөл хүлээж авснаас ажил хүссэн 8, ур чадварын нэмэгдэл олгож өгөхийг хүссэн 1, газар эзэмших зөвшөөрөл олгож өгөхийг хүссэн 1, чөлөө олгохыг хүссэн 2, цэргийн батлах дахин олгож өгөхийг хүссэн 1, асран хамгаалагч тогтоох тухай 1 өргөдөл байв. 4 өргөдлийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж, бусад өргөдлийн хариуг хугацаанд нь шийдвэрлэж, мэдэгдэх хуудсаар болон амаар мэдэгдэж шийдвэрлэв. Аймгин ИТХ, ЗДТГ-аас ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу Шинэ Үндсэн хуулийн 25 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөг сумын ИТХ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав.

Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг 2016 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн программ-д шивж Төрийн албаны салбар зөвлөлд хугацаанд нь хүргүүлэв.

Арьс ширний урамшуулалын нийт 160 өрхийн 244 ш баримтыг программд шивж ХХААГазарт хүргүүлэв. Сумын нутаг дэвсгэрт бэлчээрийг хуваарьтай ашиглах журмыг шинэчилж сумын ИТХ-аар батлуулан, байгаль орчны чиглэлээр хийсэн судалгааны жагсаалтыг гаргаж, мэдээллийн санг шинэчлэв. Сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, Улаанбураа, Баруун салаа багийн Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Хар ус, Улаан харганы чиглэлд 2 өдөр хяналтаар ажиллав.

Сумын Засаг дарга 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулж, соёлын ажлын хүрээнд 2017 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө, ЗГ-ын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу Соёлын төвд их засварын төсвийг хийлгэв.

Сумын эрүүл мэндийн төвөөс 2017 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж, Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Бүх ажилчдын ажил үүргийн хуваарь болон хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж, хурлаар цаашид хийх ажлын чиг үүрэг өгч, мэдээ мэдээллээр хангаж ажиллав.

Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн дунд сургуулийн сурагчдад томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулав. 2017 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр багш нарын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, 2016-2017 оны хичээлийн жилийн 2 дугаар улиралд хийж хэрэгжүүлсэн ажлын биелэлт, 3 дугаар улиралд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав. Судлагдахуун бүрээр мэдлэг бүтээх, тэгш хамруулах, ялгаатай байдлыг тогтоох, алдаанаас суралцахад нөлөөлөх, үйлдлийн явцаар сурагч бүрийн хөгжлийг дэмжих мөн судлах явцад хөгжих, төлөвших явц бүрийг тусгаж, хүүхэд бүрийн гарааг тодорхойлж, сургуулийн захирлаар батлуулан, үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

#### **Манхан сум:**

Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээг нэгтгэж, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хугацаанд нь хүргүүлэв. 2017 оны 01 сарын 12-13-ны өдрүүдэд Монгол улсад ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны болон Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойн арга хэмжээг ИТХ, Соёлын төвтэй хамтран тусгай хөтөлбөрөөр зохион байгууллаа.

“Олон нийтийн оролцоот сургууль” дэд төслийн багийнхан болон Булган, Цэцэг, Чандмань, Мөнххайрхан сумдын нийт 40 хүнийг хамарсан 2 өдрийн сургалтыг 22-24-ний өдрүүдэд зохион байгуулж хамтран ажиллав.

Санхүүгийн алба нь 2016 оны НДШ, ХАОАТ-ын тайланг цахим болон цаасаар гаргаж харьяа дээд байгууллагад хүргүүлэв. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, сум хөгжүүлэх сангийн зээл олгох журам боловсруулж зээлийн хороог шинэчлэн 11 иргэнд зээл олгов.

2017 оны 01-р сарын 12-ны өдрөөс тус сургуулийн III улирлын хичээл эхлэв. БХАН-ээс зохион байгуулсан “Монгол Улсад Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн сургалт тус сургууль дээр явагдаж Булганы I сургууль, Цэцэг, Мөнххайрхан, Чандмань сумдын сургуулийн төлөөлөл оролцов.

Монгол Улсад шинэ үндсэн хууль батлагдсаны болон Нутгийн өөрөө удирдах байгууллагын 25 жилийн ойд зориулсан баярын хурал, илтгэлийн хэлэлцүүлэг, АХА тэмцээн явуулж БНМАУ-ын баатар Ц.Олзвойн хөшөөнд цэцэг өргөв. Мөн Төрийн далбаа болон туг мандуулах ёслол болов. Г.Батболдын эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх “Олны хүч оломгүй далай-12” хандивын тоглолтыг 1997 оны төгсөгч нартай хамтран зохион байгуулж, тоглолтын орлого болох 1 776 150 төгрөгийг гэр бүлд нь гардуулав.

2017 оны жилийн ажлын төлөвлөгөөний төслийг хамт олноор хэлэлцүүлэн боловсруулж, туслах багшийн сургалтыг тусгай удирдамжийн дагуу төлөвлөн хэрэгжилтийг

хангуулж, сургуулийн өмнөх боловсролын тухай хуулинд өөрчлөлт оруулах саналаа хамт олноор хэлэлцүүлэн БСУГ-т албан бичгээр хүргүүлэв. Эцэг эхэд томуу болон томуу төст өвчний талаар зөвлөгөө өгч хүүхдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарч, цэцэрлэгийн гал тогоо, анги танхим, өрөө тасалгаанд чийгтэй цэвэрлэгээ, ариутгал хийж өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан, гадна орчны их цэвэрлэгээ, хур хогийг цэвэрлүүлж 2 машин хог ачуулав. Багш, ажилчид, хүүхдийн “Монгол гоёлоороо дэгжирхэн гоёцгооё” өдрийг зохион байгуулав.

Эрүүл мэндийн төв нь 4 их эмч, 23 ажилтан, нийт 27 орон тоотойгоор нийт 526 иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэв. Урьдчилан сэргийлэх үзлэгт 221 хүн хамруулсан ба эмнэлэгт 47 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна. Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 36 хүүхдийг хамруулан 2 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 14 дуудлага хүлээн авч, 0-5 насны хүүхдийг сар бүр үзлэгт хамруулж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллаж байна. Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд стандартын дагуу 210 нэр төрлийн эм олгож үйлчлэв.

2017 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Баянгол багийн Яварын хоол Рашаант, Манхан элс, Өөшийн тал, Зэрэг гол багийн Ганга, Мөнхтийн хөдөө, Хошойн ар зэрэг газруудаар явж Бөхөн, Хар сүүлтийн байршил нутагт Мязан өвчний талаар тандалт судалгаа хийж малчдад мэдээлэл өгөв. Ус цаг уур орчны шинжилгээний өртөөний техникч нартай хамтран өвлийн ургамалжилтын судалгааг Рашаант, Ганга зэрэг цэгүүдэд хийв.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ирсэн 35 дугаар албан бичгийн дагуу хүнсний чанар аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтыг зохион байгуулав. Бог малын Мязан өвчлөл гарсантай холбогдуулан Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан Зэрэг гол, Баянгол багт хяналт шалгалт хийж ажиллав.

**Эрдэнэбүрэн сүм:** НХХЯ, Монгол ажил олгогч, эздийн нэгдсэн холбоо, Залуучуудын хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих төслийн баг, аймгийн Нийгмийн бодлогын асуудал хариуцсан, Засаг даргын орлогч Ч.Уранчимэг нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ЗДТГ-ын хамт олон, албан байгууллагуудын дарга эрхлэгч нартай уулзаж, хөдөлмөр эрхлэлтийн талаар санал бодлоо солилцов. 2017 оны 01 сарын 04-нөөс графикайн дагуу багуудын ИНХ-ыг хийж, багийн ИНХ-ын даргаа сонгож, багийн Засаг даргад нэр дэвшүүлэх ажил амжилттай зохион байгуулав. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны үндсэн чиглэлийг бүх баг, байгууллага, ИТХ, ЗДТГ-ын ажилтнуудад хүргэв.

2017 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 2016 оны 11 сарын 25-наас 2017 оны 01 сарын 07-ны хооронд зохион байгуулж 617 бэлтгэл үүрэгтний тооцоо хийн аймгийн ЗДТГ-ын цэргийн штабт сайн үнэлгээтэй тушаав.

Үндсэн хуулийн 25 жилийн ойн арга хэмжээг хөтөлбөр гарган сумын ИТХ, ЗДТГ, аймаг дахь нутгийн зөвлөлийн тэргүүлэгчид, залуучуудтайгаа хамтран 2017 оны 01 сарын 13-14-ний өдрүүдэд тэмдэглэв.

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР